



ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙД Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

**МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,  
ДОТООД ХЭРГИЙН САЙД**

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,  
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,  
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,  
http://www.mojha.gov.mn

2019.03.22 № 1-1/1273  
танай 2019.05.22 -ны № 01/1136 -т

**Улсын нэгдсэн бүртгэлд  
бүртгэсэн тухай**

Зам, тээврийн хөгжлийн сайдын дор дурдсан тушаалуудыг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлд бүртгэснийг мэдэгдье. Үүнд:

1.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны “Журам батлах тухай” /Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам/ 274 дүгээр тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 428 дугаарт;

2.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Агаарын замуудыг тогтоох тухай” 60 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 428 дугаарт;

3.Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Журам батлах тухай” /Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам/ 78 дугаар тушаалыг захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 428 дугаарт.

  
Ц.НЯМДОРЖ

Doc.said a4.2019

151600596





Захиргааны хэмээх эрх зүйн  
актын улсын нэгдсэн санд  
2019 оны 03 сарын 22-нд  
өдрийн 4287 дугаар бүртгэл

## МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2018 оны 12 сарын 07 өдөр

Дугаар 274

Улаанбаатар хот

### Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Авто замын тухай хуулийн 30 дугаар зүйлийн 30.2 дахь хэсгийг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авах журам”-ыг хавсралтаар баталсугай.

2. Журмыг хэрэгжүүлж ажиллахыг Авто замын бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Д.Доржханд/, “Зам, тээврийн хөгжлийн төв” ТӨҮГ /Р.Буд/-т, журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/-т тус тус даалгасугай.


3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн хөгжлийн сайдын 2016 оны 10 дугаар сарын 21-ний өдрийн 57 дугаар тушаалын 1 дүгээр хавсралтаар баталсан “Олон улсын болон улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах цэгийн зохион байгуулалт, орлогыг төвлөрүүлэх, зарцуулах үйл ажиллагааны журам”-ыг хүчингүй болсонд тооцсугай.



619

18 12 18  
Дутуу  
080727

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2018 оны  
12 дугаар сарын 07-ны өдрийн 27 дугаар  
тушаалын хавсралт



## ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ БОЛОН ТУСГАЙ ЗОРИУЛАЛТЫН АВТО ЗАМ, ЗАМЫН БАЙГУУЛАМЖ АШИГЛАСНЫ ТӨЛБӨР АВАХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл

- 1.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс өмчийн хэлбэр, харьяаллыг үл харгалзан авто зам, замын байгууламж ашигласны төлбөр авахтай холбогдон үүсэх харилцааг энэхүү журмаар зохицуулна.
- 1.2. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламж ашигласны төлбөрийн орлогыг улсын авто замын санд төвлөрүүлж, төлбөр авах цэг байгуулах, засварлаж тохижуулах, төлбөр авах үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх болон Авто замын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.3, 24.4, 24.5-д заасны дагуу зарцуулна.
- 1.3. Тусгай зориулалтын авто замаар зорчиж буй тусгай зориулалтаас бусад тээврийн хэрэгслээс авах төлбөр нь Засгийн газраас тогтоосон олон улс, улсын чанартай авто замд авах төлбөрийн хэмжээнээс хэтрэхгүй байна.
- 1.4. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчиж байгаа тээврийн хэрэгслээс авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг авто замын судалгаа, шинжилгээ хөгжлийн асуудал эрхэлсэн байгууллага (цаашид "Зам, тээврийн хөгжлийн төв" гэх) зохион байгуулж хэрэгжүүлнэ.

### Хоёр. Төлбөр авах үйл ажиллагаанд тавигдах шаардлага

- 2.1. Олон улс, улсын чанартай болон тусгай зориулалтын авто зам, гүүрээс авто зам ашигласны төлбөр авна. Төлбөр авахдаа тээврийн хэрэгслийн төрөл, ангилал, бүх жинг харгалзан Засгийн газраас тогтоосон төлбөрийн хэмжээг баримтална.
- 2.2. Тусгай дуут болон гэрлэн дохио хэрэглэн албан үүргээ гүйцэтгэж байгаа эмнэлгийн түргэн тусламж, зэвсэгт хүчин, хил хамгаалах, цагдаа, шүүхийн шийдвэр гүйцэтгэх, онцгой байдлын алба, төрийн тусгай хамгаалалтын болон хөгжлийн бэрхшээлтэй иргэний зориулалттай тээврийн хэрэгслийг төлбөрөөс чөлөөлнө.
- 2.3. Энэ журмын 2.2-т зааснаас бусад бүх тээврийн хэрэгсэл авто зам, замын байгууламж ашигласны төлбөр төлөх үүрэгтэй.
- 2.4. Төлбөр авах үйл ажиллагааг авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж, тээврийн хэрэгслийн хөдөлгөөнд саад учруулахгүйгээр зохион байгуулна.
- 2.5. Авто зам, замын байгууламж ашигласан төлбөрийн хэмжээг заасан тасалбарыг төлбөр төлөгчдөд олгоно. Тасалбарт авто замын чиглэл, дугаар, төлбөр авах цэгийн нэр, төлбөрийн хэмжээ, огноог тусгаж, санхүүгийн тэмдгээр баталгаажуулсан байна. 6/9
- 2.6. Төлбөр авах үйл ажиллагааг төлбөр авах замын эхлэл болон төгсгөлийн цэгт байгуулсан байнгын болон байнгын бус ажиллагаатай төлбөр авах цэгт (цаашид "төлбөр авах цэг" гэнэ.)

Баттууш  
18 12 12

төвлөрүүлэн зохион байгуулна. Төлбөр авах цэгт ахлагч, төлбөр хураагчид, авто пүү ажиллаж байгаа цэгт жин хэмжигч ажилтан ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд авто зам, тээврийн хяналтын улсын байцаагч, замын цагдаа, харуул, хамгаалагч нар байрлан ажиллаж болно.

2.7. Авто зам ашигласны төлбөр авах цэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдож, аюул осолгүй ажиллах нөхцөл боломжоор хангагдсан байна.

2.8. Төлбөртэй авто зам нь дараагийн төлбөр авах цэг хүртэл үргэлжлэх бөгөөд тээврийн хэрэгсэл дараагийн төлбөртэй авто замаар зорчих бол дахин төлбөр төлнө. Төлбөртэй авто замын төгсгөлийн цэг нь эсрэг урсгалдаа эхлэлийн цэг болно.

2.9. Төлбөр авах цэгийн орох хэсэгт тээврийн хэрэгслээс төлбөр авсныг нотлох тасалбар олгон бүртгэлжүүлж, дараагийн төлбөр авах цэгт тасалбараа шалгуулна. Тасалбар байхгүй тохиолдолд зорчсон замынхаа төлбөрийг төлж дараагийн замд зорчих төлбөрийг төлж тасалбар авна.

2.10. Тухайн авто зам, замын байгууламжаар байнга зорчиж, тээвэрлэлт хийдэг иргэн, байгууллага авто зам ашигласны төлбөрийг гэрээ байгуулан урьдчилан төлж болно. Төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд 30 хувиар хөнгөлөлт үзүүлнэ.

2.11. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчих тээврийн хэрэгслийн бүх жин, овор хэмжээ ба уртыг шалгаж, MNS 4598-2011 стандартад нийцсэн эсэхийг тогтооно. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн жин, овор, урттай тээврийн хэрэгслийг тухайн авто замаар зорчихыг зөвшөөрөхгүй.

2.12. Төлбөр авах цэгээс хоёр тийш авто замын дагууд 500 метр дотор аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, зар сурталчилгааны самбар байрлуулахгүй.

2.13. Төлбөр авах цэг нь хөдөлгөөний эрчмийн тооллогыг "Улсын чанартай авто замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн тооллого хийх журам"-ын дагуу болон энгийн тооллогын аргаар хийж болно.

### **Гурав. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

3.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг бодлого, чиглэлээр хангаж, олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөрийн орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.2. Энэхүү журмын 5.1-д заасан үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний зардлыг батлан, Зам, тээврийн хөгжлийн төв, зам хариуцагч болон бусад холбогдох байгууллагатай гэрээ хэлцэл байгуулан үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

3.3. Төлбөртэй авто зам, замын байгууламж, төлбөр авах цэгийн байршлыг авто замын сүлжээний зурагт тэмдэглэж, мэдээлэх ажлыг зохион байгуулна.

### **Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн төвийн чиг үүрэг**

4.1. Зам, тээврийн хөгжлийн төв нь олон улс, улсын чанартай авто замын тогтоосон чиглэлд төлбөр авах цэг байгуулан үйл ажиллагааг зохион байгуулж, авто зам ашигласны төлбөрийн орлогыг авто замын сангийн дансанд төвлөрүүлнэ.

4.2. Төлбөр авах цэгийн байр, авто пүү, түр саатуулах ил зогсоолын талбайн бүрэн бүтэн байдал, ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийн самбар байрлуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

12 12 12

төвлөрүүлэн зохион байгуулна. Төлбөр авах цэгт ахлагч, төлбөр хураагчид, авто пүү ажиллаж байгаа цэгт жин хэмжигч ажилтан ажиллах бөгөөд шаардлагатай тохиолдолд авто зам, тээврийн хяналтын улсын байцаагч, замын цагдаа, харуул, хамгаалагч нар байрлан ажиллаж болно.

2.7. Авто зам ашигласны төлбөр авах цэг нь шаардлагатай техник, тоног төхөөрөмжөөр тоноглогдож, аюул осолгүй ажиллах нөхцөл боломжоор хангагдсан байна.

2.8. Төлбөртэй авто зам нь дараагийн төлбөр авах цэг хүртэл үргэлжлэх бөгөөд тээврийн хэрэгсэл дараагийн төлбөртэй авто замаар зорчих бол дахин төлбөр төлнө. Төлбөртэй авто замын төгсгөлийн цэг нь эсрэг урсгалдаа эхлэлийн цэг болно.

2.9. Төлбөр авах цэгийн орох хэсэгт тээврийн хэрэгслээс төлбөр авсныг нотлох тасалбар олгон бүртгэлжүүлж, дараагийн төлбөр авах цэгт тасалбараа шалгуулна. Тасалбар байхгүй тохиолдолд зорчсон замынхаа төлбөрийг төлж дараагийн замд зорчих төлбөрийг төлж тасалбар авна.

2.10. Тухайн авто зам, замын байгууламжаар байнга зорчиж, тээвэрлэлт хийдэг иргэн, байгууллага авто зам ашигласны төлбөрийг гэрээ байгуулан урьдчилан төлж болно. Төлбөрийг урьдчилан төлсөн тохиолдолд 30 хувиар хөнгөлөлт үзүүлнэ.

2.11. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжаар зорчих тээврийн хэрэгслийн бүх жин, овор хэмжээ ба уртыг шалгаж, MNS 4598-2011 стандартад нийцсэн эсэхийг тогтооно. Зөвшөөрөгдсөн хэмжээнээс хэтэрсэн жин, овор, урттай тээврийн хэрэгслийг тухайн авто замаар зорчихыг хориглоно.

2.12. Төлбөр авах цэгээс хоёр тийш авто замын дагууд 500 метр дотор аливаа үйлдвэрлэл, үйлчилгээ эрхлэх, зар сурталчилгааны самбар байрлуулахыг хориглоно.

2.13. Төлбөр авах цэг нь хөдөлгөөний эрчмийн тооллогыг "Улсын чанартай авто замд тээврийн хэрэгслийн хөдөлгөөний эрчмийн тооллого хийх журам"-ын дагуу болон энгийн тооллогын аргаар хийж болно.

### **Гурав. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын чиг үүрэг**

3.1. Авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага нь авто зам ашигласны төлбөр авах үйл ажиллагааг бодлого, чиглэлээр хангаж, олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөрийн орлого, зардал, хөрөнгө оруулалтын төлөвлөгөөг батлан хэрэгжилтэд хяналт тавьж ажиллана.

3.2. Энэхүү журмын 5.1-д заасан үйл ажиллагаа, төсөл арга хэмжээний зардлыг батлан, Зам, тээврийн хөгжлийн төв, зам хариуцагч болон бусад холбогдох байгууллагатай гэрээ хэлцэл байгуулан үүрэг, чиглэл өгч биелэлтийг хангуулах арга хэмжээ авна.

3.3. Төлбөртэй авто зам, замын байгууламж, төлбөр авах цэгийн байршлыг авто замын сүлжээний зурагт тэмдэглэж, мэдээлэх ажлыг зохион байгуулна.

### **Дөрөв. Зам, тээврийн хөгжлийн төвийн чиг үүрэг**

4.1. Зам, тээврийн хөгжлийн төв нь олон улс, улсын чанартай авто замын тогтоосон чиглэлд төлбөр авах цэг байгуулан үйл ажиллагааг зохион байгуулж, авто зам ашигласны төлбөрийн орлогыг авто замын сангийн дансанд төвлөрүүлнэ.

4.2. Төлбөр авах цэгийн байр, авто пүү, түр саатуулах ил зогсоолын талбайн бүрэн бүтэн байдал, ажиллагсдын аюулгүй ажиллагаа, эрүүл ахуйн нөхцөлийг хангаж, хууль тогтоомж, үйл ажиллагааг сурталчилсан мэдээллийн самбар байрлуулан хөдөлгөөний аюулгүй байдлыг хангаж ажиллана.

Баттуу 9  
18 12 12

4.3. Төлбөр авах үйл ажиллагааг цахимжуулах, дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх ажлыг зохион байгуулан хэрэгжүүлж, төлбөр авах цэгээр нэвтэрч байгаа тээврийн хэрэгслийг төрөл, улсын дугаараар бүртгэж, цахим сан бүрдүүлнэ.

4.4. Төлбөр авах цэгүүдийн орлогыг дараа өдөрт багтаан авто замын сангийн дансанд төвлөрүүлж, сар бүрийн тайланг тухайн сарын 25-ны өдрийн дотор авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагад ирүүлнэ. Мөн төлбөр авах үйл ажиллагааны орлого, зарлагын улирал, жилийн тайланг тогтоосон хугацаанд гарган холбогдох байгууллагад хүргүүлнэ.

#### **Тав. Авто зам ашигласны төлбөрийн орлогын зарцуулалт**

5.1. Олон улс, улсын чанартай авто замаар зорчиж буй тээврийн хэрэгслээс тогтоосон тарифын дагуу авсан авто зам ашигласны төлбөрийн орлогыг дараах үйл ажиллагаа, төсөл арга хэмжээг санхүүжүүлэхэд зарцуулна.

5.1.1. Төлбөр авах цэгийн байр барих түүний зам талбай, зогсоол байгуулах, тохижуулах, шаардлагатай тоног төхөөрөмж, техник хэрэгсэл худалдан авах арга хэмжээний зардалд;

5.1.2. Төлбөр авах үйл ажиллагааны талаарх хууль тогтоомж, дүрэм журмыг олон нийтэд тайлбарлан таниулах, тухайн чиглэлийн авто зам, замын байгууламжийн талаарх мэдээ, мэдээллээр зам хэрэглэгчдийг хангах зардалд;

5.1.3. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн ашиглалтын болон хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах "Хөдөлгөөнт эргүүл" ажиллуулах зардалд;

5.1.4. Авто замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, техник ашиглалтын түвшин тогтоох, хөдөлгөөний эрчмийн тооллого хийх болон судалгаа, шинжилгээний ажлын зардалд;

5.1.5. Авто замын бүртгэл мэдээллийн санг шаардлагатай техник, тоног төхөөрөмж, программ хангамж, мэдээллээр хангах зардалд;

5.1.6. Олон улс, улсын чанартай авто зам хариуцагч төрийн өмчит байгууллагын үйлдвэрлэлийн баазыг хөгжүүлэх, авто замын салбарт дэвшилтэд техник, технологи нэвтрүүлэх үйл ажиллагаанд;

5.1.7. Олон улс, улсын чанартай авто зам, замын байгууламжийн урсгал засвар, арчлалтын ажлын зардалд;

5.2. Төлбөр авах үйл ажиллагааны удирдлага з зохион байгуулалт, төлбөр авах цэгийн зардлыг авто зам ашигласны төлбөрөөс тухайн сар бүрд төвлөрүүлсэн нийт орлогын дүнгээс 40 хувиар тооцож санхүүжүүлнэ. Энэ зардалд төлбөр авах үйл ажиллагааны удирдлага зохион байгуулалт, ажиллагсдын цалин, урсгал зардал, хяналт шалгалт, төлбөр авах цэгийн хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, цахим сан бүрдүүлэх, зорчигчдыг мэдээ мэдээллээр хангах зэрэг төлбөр авах үйл ажиллагаатай холбоотой бүх зардал багтана.

5.3. Журмын 5.1-д заасан зардлыг санхүүжүүлэх төсөл арга хэмжээний саналыг Зам, тээврийн хөгжлийн төвөөс боловсруулж, авто замын асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагаар батлуулан хэрэгжүүлнэ.

5.4. Журмын 5.2-д заасан зардлыг авто зам ашигласны төлбөрийн сарын орлогын тайланг үндэслэн дараа сарын 05-ны өдрийн дотор Зам, тээврийн хөгжлийн төвийн дансанд шилжүүлнэ. 619

5.5. Олон улс, улсын чанартай авто зам ашигласны төлбөрийн жилийн орлогын төлөвлөгөөг давуулан биелүүлсэн тохиолдолд давсан орлогын 30 хувийг төлбөр авах үйл ажиллагааг зохион байгуулж хэрэгжүүлсэн байгууллагад урамшуулал болгон олгоно.

Батал  
18 12 12

## Зургаа. Бусад

- 6.1. Төлбөр авах цэгийн ажиллах дотоод журмыг Зам, тээврийн хөгжлийн төв тогтоож хэрэгжүүлнэ.
- 6.2. Төлбөр авах цэгийн хэвийн үйл ажиллагаа, ажиллагсдын аюулгүй байдлыг Зам, тээврийн хөгжлийн төв, түүнээс томилогдсон ажилтан. төлбөр авах цэгийн ахлагч бүрэн хариуцна.
- 6.3. Авто замын тухай хууль болон энэхүү журмын заалтыг зөрчсөн хувь хүн, хуулийн этгээдэд холбогдох хууль тогтоомжийн дагуу хариуцлага хүлээлгэнэ.

---o0o---

619

Бүтэц  
18 12 12





Захиргааны хэлтэс  
АКТЫН УЛСЫН НЭГДСЭН  
2019 оны 03 сарын 22  
өдрийн 4283

МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
СЛАЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 15 өдөр

Дугаар 78

Улаанбаатар

Журам батлах тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2 дахь хэсэг, Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. "Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам"-ыг нэгдүгээр, гэрчилгээний загварыг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

2. Энэхүү тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт- шинжилгээ, үнэлгээ, дотоод аудитын газар /М.Энхболд/, Төмөр зам, далайн тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /А.Батболд/-т тус тус даалгасугай.

САЙД

Б.ЭНХ-АМГАЛАН

Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод  
гэрчилгээ олгох журмын төсөлд хийсэн  
нөлөөллийн шинжилгээ

1. Журам боловсруулах үндэслэл, шаардлага

Монгол Улсын Их Хурлаас Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгыг 2017 оны 05 дугаар сарын 25-ны өдөр баталсан ба уг хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.12-т заасан “усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загварыг батлах” гэсэн заалтыг үндэслэн энэхүү журмыг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн боловсруулав.

2. Журмын төслийн ерөнхий бүтэц, зохицуулах харилцаа, хамрах хүрээ

“Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ын төсөл нь ерөнхий зүйл, гэрчилгээжүүлэх объект, гэрчилгээжүүлэх объектод тавигдах ерөнхий шаардлага, гэрчилгээ авахад бүрдүүлэх баримт бичиг, гэрчилгээ хүссэн өргөдлийг хянан шийдвэрлэх, гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа, гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг, гэрчилгээний хугацааг сунгах, гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох, хяналт тавих, мэдээллийн сан бүрдүүлэх гэсэн 11 хэсгээс бүрдэнэ.

Журмаар усан замын объект эзэмшигч, өмчлөгч, түрээслэгч иргэн, аж ахуйн нэгж, байгууллагын эрх, үүрэг, хариуцлагыг тодорхойлж зохицуулна.

Журам нь усан замын объект болох усан замын тээврийн хэрэгслийн зогсоол, усан замын төв буудал, усан замын тээврийн хэрэгслийг чиглүүлэгч гэрэлт цамхаг, бусад хөвөгч тоног төхөөрөмж болон эргийн байгууламжийн ашиглалтын аюулгүй байдалтай холбоотой гэрчилгээ олгох, сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох асуудлыг хамаарна.

3. Журам батлагдсаны дараа эрх, хууль ёсны ашиг сонирхол нь аливаа байдлаар хөндөгдөж болохуйц бүлгийг тодорхойлох

Журмын төслийг тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага болон харъяа Далайн захиргааны вэбсайтад нийтлүүлж усан замын тээврийн үйлчилгээ үзүүлж буй нийт иргэд, хуулийн этгээдүүдэд болон Хөвсгөл нуурт усан замын тээврийн үйлчилгээ үзүүлж буй иргэд, хуулийн этгээдийн дунд хэлэлцүүлж саналыг авч тусгасан болно. /"Монголын Завьчдын нэгдсэн холбоо" НҮТББ-ын албан бичгийг хавсаргав/

Журам батлагдсаны дараа усан замын объект ашиглаж буй болон усан замын тээврийн хэрэгслээр ажил, үйлчилгээ эрхэлж буй иргэн, хуулийн этгээдийн эрх, хууль ёсны ашиг сонирхол ямар нэг байдлаар хөндөгдөхгүй.

4. Хүний эрх, эрх чөлөөг хязгаарласан, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд

суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулж байгаа эсэх

Журам нь хүний эрх, эрх чөлөө, өрсөлдөөнийг хязгаарласан, эдийн засаг, нийгмийн болон бусад үйл ажиллагаанд саад хориг учруулсан, аливаа хүнд суртал, авлига гарах нөхцөл боломж бүрдүүлсэн байж болзошгүй зохицуулалт агуулаагүй болно.

Журамд ялгаварлан гадуурхсан эсхүл аль нэг бүлэгт давуу байдал үүсгэсэн, жендерийн эрх тэгш байдлыг хөндсөн, дотоодын аж ахуйн нэгж болон гадаадын хөрөнгө оруулалттай аж ахуйн нэгж хоорондын өрсөлдөөнд нөлөөлсөн, хязгаарлагдмал өрсөлдөөний улмаас үнийн хөөрөгдөл бий болгосон заалтыг тусгаагүй болно.

Мөн аль нэг аж ахуйн нэгжид, ялангуяа зах зээлд шинээр орж ирж байгаа иргэн, аж ахуйн нэгжүүдийн хувьд бэрхшээл, хүндрэл бий болгох, төрийн байгууллага болон бусад иргэн, хуулийн этгээдэд захиргааны шинж чанартай нэмэлт ачаалал бий болгох, аж ахуйн нэгжийн үйл ажиллагааг зогсооход хүргэсэн, хэрэглэгчдийн эрх ашигт нөлөөлсөн зохицуулалтыг агуулаагүй болно.

5. Тухайн асуудлыг зохицуулж байгаа урьд нь батлагдсан шийдвэр байгаа эсэх

Журамд тусгагдсан харилцааг өмнө нь зохицуулсан ямар нэгэн батлагдсан шийдвэр байхгүй болно.

6. Журмыг хэрэгжүүлэхэд шаардлагатай хүний нөөц, техник, эдийн засгийн тооцоо

Иймд тавигдаж буй өнөөгийн шаардлагын дагуу “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ыг шинээр боловсруулсан бөгөөд түүнийг хэрэгжүүлэхэд хүний нөөц, техникийн болон эдийн засгийн зардал гарахгүй болно.

САЙД  Б.ЭНХ-АМГАЛАН

Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой  
объектод гэрчилгээ олгох журмын төслийн  
танилцуулга

2019.01.04

Монгол Улсын хэмжээнд нуур, гол, мөрөн бүхий 12 аймаг байдаг ч зөвхөн Хөвсгөл, Сэлэнгэ аймгуудад усан замын тээврийн үйлчилгээ, үйл ажиллагаа явагдаж Хөвсгөл нуураар өргөн хэрэглээний бараа, шатах тослох материал Ханх, Хатгал боомтын хооронд тээвэрлэж баруун аймгуудыг хангаж байсан ба Сэлэнгэ мөрнөөр гол төлөв мод бэлтгэл, үр тарианы тээвэрлэлт 1950-1990 хүртэл хийгдэж байв.

Энэ үед баригдсан усан замын объектууд болох Тээврийн яам /хуучин нэрээр/-ны харъяа Хөвсгөлийн Усан замын газар /хуучин нэрээр/-т 1952-1989 оныг хүртэл ачаа тээврийн зориулалтаар ашиглагдаж- байсан дунд оврын усан онгоц, чиргүүл онгоцны 5 зогсоол Хөвсгөл нуурт, Сэлэнгэ мөрөнд 1, нийт 6 зогсоол байгаа ба бусад аймгуудад усан замын тээврийн хэрэгслийн зогсоол, чиглүүлэгч гэрэлт цамхаг, бусад хөвөгч төхөөрөмж одоогоор байхгүй болно.

Улс орон зах зээлийн эдийн засгийн харилцаанд шилжсэн үеэс эдгээр зогсоол нь хувьчлагдан хувийн өмч болж, төрөөс үл хамаарах болсон ч тэдгээрийг ашиглах явцад аюулгүй байдлыг нь хангах асуудал хурцаар тавигдаж байна.

Сүүлийн жилүүдэд дотоодын аялал жуулчлал хурдацтай хөгжиж, усан замын тээврийн хэрэгслээр аялал жуулчлалд хамрагдах гадаад дотоодын иргэдийн тоо өсөн нэмэгдэхийн хэрээр усан замын объектын даацыг хэтрүүлэх, усанд хүний амь нас осолдох, бэртэж гэмтэх эрсдэл нэмэгдэж байна.

Мөн Хөвсгөл нуурт 2000 оны дундуур иргэд, аж ахуйн нэгж байгууллагын 10 хүрэхгүй усан замын тээврийн хэрэгсэл тоологдож байсан бол өнөөдөр 80 гаруй болж цаашид улам бүр нэмэгдэх хандлагатай болж байгаа, түүнчлэн усан замын зорчигч тээвэрт өсөлт гарч 2002 онд 6000 орчим зорчигч тээвэрлэж байсан бол сүүлийн 5 жил /2012-2017/-ийн дунджаар 51000 орчим зорчигч тээвэрлэсэн нь усан замын объектын тоог нэмэгдүүлэхийг шаардаж байна.

Өсөн нэмэгдэж буй эдгээр хэрэгцээ шаардлагыг хангах үүднээс тус яам 2007-2015 онуудад дотоодын усан замын тээврийн салбарт улсын төсвөөс 5 орчим тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтыг хийж хөвөгч гүүр 4, ган татлагат хөвөгч хэрэгсэл 3, бетонон зогсоол 1, хөвөгч зогсоол 4 болон усан замын тээврийн хэрэгслийн хөвөлтийн аюулгүй байдлын 37 хөвөгч тэмдэг, тэмдэглэгээ зэрэг объектыг барьж байгуулан орон нутагт нь хүлээлгэн өгсөн билээ.

Гэсэн ч эдгээр объектыг хариуцах эзнийг томилох, цалин хөлс зэрэг холбогдон гарах зардлыг бүрэн гүйцэд шийдвэрлэн тогтвортой ажиллуулах талаар нутгийн захиргааны байгууллагаас учир дутагдалтай ажиллаж байгаа, түүнчлэн усан замын объектын ажиллагаа улирлын чанартай байгаагаас шалтгаалан тэдгээрийн аюулгүй байдал сайнгүй байгаа тул гэрчилгээжүүлж эзэнтэй болгох шаардлагатай байна.

Иймээс 2017 оны 07 дугаар сарын 01-нээс хүчин төгөлдөр мөрдөгдөж буй Усан замын тээврийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын 6 дугаар зүйлийн

6.1.12 дахь заалтад “усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам, гэрчилгээний загварыг батлах” гэж заасны дагуу энэхүү журмын төслийг Захиргааны ерөнхий хуульд нийцүүлэн шинээр боловсруулав.

Энэхүү журмаар усан замын объектын ашиглалтын аюулгүй байдлыг болон эргийн ба бусад хөвөгч төхөөрөмжийн бүрэн бүтэн байдал, техникийн аюулгүй ажиллагааг хангах, усан замын объектод учирч болох эрсдэлээс урьдчилан сэргийлэх зорилгоор тэдгээрт үзлэг хяналт хийж “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ”-г 3 жил тутамд олгохтой холбогдсон харилцааг зохицуулна.

“Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ын төсөл нь 11 хэсэг, гэрчилгээний загвараас бүрдэнэ.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.1-д “захиргааны хэм хэмжээний актын төслийг тухайн захиргааны байгууллагын цахим хуудас болон мэдээллийн самбарт 30-аас доошгүй хоногийн хугацаанд байрлуулж санал авна” гэж заасны дагуу журмын төсөлд санал авах ажилтны овог нэр, цахим шуудангийн хаяг, утасны дугаарын хамтаар Зам, тээврийн хөгжлийн яамны болон харъяа Далайн захиргааны [www.monmarad.gov.mn](http://www.monmarad.gov.mn) цахим хуудаст 2018 оны 10 дугаар сарын 12-ноос 40 хоногийн хугацаанд байршуулж, ил тод, нээлттэй мэдээлсэн. Цахим хуудаст байршуулах хугацаанд иргэн, хуулийн этгээдээс ямар нэгэн санал ирээгүй болно.

Захиргааны ерөнхий хуулийн 62 дугаар зүйлийн 62.2 дахь хэсэгт заасны дагуу хууль ёсны ашиг сонирхол нь хөндөгдөх бүлгийн хүрээнд (иргэд, байгууллага, аж ахуйн нэгж) хэлэлцүүлэг хийсэн ба хэлэлцүүлэг зохион байгуулсан “Монголын завьчдын холбоо” НҮТББ-ын албан бичгийн хуулбарыг хавсаргав.

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ

Зам. тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 05 дугаар  
сарын 15-ны өдрийн 78 дугаар тушаалын  
нэгдүгээр хавсралт

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТОД ГЭРЧИЛГЭЭ ОЛГОХ ЖУРАМ

### Нэг. Ерөнхий зүйл.

1.1. Энэхүү журмаар Монгол Улсын нутаг дэвсгэрт орших усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объект /цаашид "объект" гэх/-д гэрчилгээ олгохтой холбогдон үүсэх харилцааг зохицуулна.

1.2. Объектыг гэрчилгээжүүлэх ажлыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага /цаашид "төрийн захиргааны төв байгууллага" гэх/ Монгол Улсын хууль тогтоомжоор тавигдсан нөхцөл шаардлагын дагуу эрхлэн гүйцэтгэнэ.

1.3. Объектын гэрчилгээ нь иргэн, хуулийн этгээдийн үл хөдлөх хөрөнгийн өмчлөлийг тогтоохгүй.

1.4. Энэхүү журмын хэрэгжилтэд Мэргэжлийн хяналтын байгууллагаас эрх олгогдсон Усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв болон харъяа мэргэжлийн байгууллагын усан замын тээврийн хяналтын улсын байцаагчид хяналт тавина.

1.5. Тээвэрлэгч нь ашиглалтын гэрээ байгуулахдаа тухайн объект нь гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан эсэхийг магадална.

1.6. Гэрчилгээжүүлэх ажиллагаанд ил тод, нээлттэй, шуурхай, хууль тогтоомжийг чанд мөрдөх, аюулгүй байдлыг хангах зарчмыг баримтална.

### Хоёр. Гэрчилгээжүүлэх объект

2.1 Дараах объектыг гэрчилгээжүүлнэ:

- 2.1.1. усан замын тээврийн хэрэгслийн зогсоол;
- 2.1.2. усан замын төв буудал;
- 2.1.3. чиглүүлэгч гэрэлт цамхаг;
- 2.1.4. бусад хөвөгч тоног төхөөрөмж.

Гурав. Гэрчилгээжүүлэх объектод тавигдах  
ерөнхий шаардлага

3.1. Гэрчилгээжүүлэх объект нь дараах нөхцөлийг хангасан байхаас гадна объектын төрөл, онцлогоос шалтгаалан энэхүү журмын хавсралтад заасан нөхцөл шаардлагыг хангасан байна. Үүнд:

3.1.1. усан замын тээврийн тухай хууль тогтоомжид заасан усан замын тээврийн аюулгүй байдлын шаардлагыг хангасан байх;

3.1.2. объектын ашиглалт, үйлчилгээг хэрэгжүүлэх технологи, техник ашиглалтын зааврын бүрдлийг хангасан байх;

3.1.3. объектын ашиглалтын үеийн аюулгүй байдлыг хангаж, хүний амь нас эрсдэх, эрүүл мэнд, байгаль орчинд хохирол учруулахгүй, осол аваар гаргахгүй байх урьдчилсан нөхцлийг бүрдүүлсэн байх;

3.1.4. объектод дэвшилтэт техник, технологи нэвтрүүлсэн, өрсөлдөх чадварыг сайжруулсан;

3.1.5. аюулгүй, чанартай, соёлтой, шуурхай ажил үйлчилгээг сонгон хэрэглэх боломж, нөхцөлөөр хэрэглэгчдийг хангасан, болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлсэн байх.

### **Дөрөв. Гэрчилгээ авахад бүрдүүлэх баримт бичиг**

4.1. Объектын гэрчилгээ авах иргэн, хуулийн этгээд дараах баримт бичгийг бүрдүүлнэ. Үүнд:

4.1.1. өмчлөгчөөс зохих журмын дагуу гаргасан хүсэлт, өргөдөл; /Уг хүсэлтэд тухайн объектод хамаарах гэрчилгээний төрлийг тодорхой заах/

4.1.2. объектын өмчлөгч нь иргэн бол иргэний үнэмлэхийн хуулбар;

4.1.3. объектын өмчлөгч нь хуулийн этгээд бол улсын бүртгэлийн гэрчилгээний нотариатаар баталгаажуулсан хуулбар;

4.1.4. гэрчилгээжүүлэх объектын талаарх дэлгэрэнгүй танилцуулга;

4.1.5. тухайн объектын ашиглалтын үедэх техникийн аюулгүй байдлыг харуулсан засвар, өөрчлөлтийн бүртгэл бүхий бичиг баримт, засвар өөрчлөлтийг бүртгэсэн тэмдэглэл, ашиглалтын заавар, техникийн зураг, схем;

4.1.6. объект нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгааг нотолсон баримт бичиг /тухайн объектын талаарх мэргэжлийн байгууллага, эрх бүхий этгээдийн тодорхойлт, акт г.м/;

4.1.7. үл хөдлөх эд хөрөнгө өмчлөх эрхийн улсын бүртгэлийн гэрчилгээ, өмч хувьчлалын шийдвэр, газар өмчлөх, эзэмших эрхийн гэрчилгээ болон түрээсийн гэрээний хуулбар /нотариатаар баталгаажуулсан/ болон бусад баримт бичиг.

### **Тав. Объектын гэрчилгээ авах хүсэлтийг хянан шийдвэрлэх**

5.1. Иргэн, хуулийн этгээд нь объектын гэрчилгээ авах тухай хүсэлтээ төрийн захиргааны төв байгууллагад гаргана.

5.2. Төрийн захиргааны төв байгууллага нь объектын гэрчилгээ авах хүсэлт гаргасан иргэн, хуулийн этгээдийн хүсэлтийг судлан дүгнэлт гаргах орон тооны бус байнгын ажлын хэсгийг байгуулна.

5.3. Уг ажлын хэсэг нь хүсэлт гаргагчийн баримт бичгийн иж бүрдэл, тухайн объект нь гэрчилгээ олгоход тавигдаж байгаа нөхцөл, шаардлагыг хангасан байдлыг нягтлан шалгаж, ажлын 14 хоногийн дотор гэрчилгээ олгох эсэх талаар дүгнэлт гаргана.

5.4. Усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн нь ажлын хэсгээс гаргасан дүгнэлтийг үндэслэн ажлын 7 хоногийн дотор асуудлыг шийдвэрлэнэ.

5.5. Шаардлагатай гэж үзвэл энэхүү журмын 5.3-т заасан хугацааг ажлын 7 хоногийн хугацаагаар сунгаж болно.

5.6. Төрийн захиргааны төв байгууллага нь тухайн объектод гэрчилгээ олгохоос татгалзсан тохиолдолд хүсэлт гаргагчид энэ тухай албан бичгээр ажлын 5 хоногт багтаан мэдэгдэнэ.

5.7. Ажлын хэсэг шаардлагатай гэж үзвэл гэрчилгээ авах хүсэлт гаргагчийн үйл ажиллагаа, үйлдвэрийн бааз, техник хангамжийн нөхцөл байдалтай танилцаж болно.

## **6. Гэрчилгээжүүлэх үйл ажиллагаа**

6.1 Гэрчилгээжүүлэх үйл ажиллагааг төрийн захиргааны төв байгууллага дараах байдлаар хэрэгжүүлнэ. Үүнд:

6.1.1. гэрчилгээжүүлэлтэд тавигдах нөхцөл, шаардлагыг боловсруулах батлах, боловсронгуй болгох, үр нөлөөг дээшлүүлэх;

6.1.2. гэрчилгээ олгох, хугацааг сунгах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

6.1.3. гэрчилгээжүүлэлтэд хамрагдах объектын техникийн нөхцөл, баримт бичгийг хянах;

6.1.4. гэрчилгээ бүхий объект нь гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хангаж байгаа эсэхийг хянах, түдгэлзүүлэх, хүчингүй болгох;

6.1.5. усан замын тээврийн үйл ажиллагаанд оролцогч иргэн, хуулийн этгээдээс гэрчилгээжүүлэлтийн нөхцөл, шаардлагыг хэрхэн мөрдөж байгаад хяналт тавьж биелэлтийг хангуулах

6.1.6. гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг бүрдүүлэх, хөтлөх.

6.2. Төрийн захиргааны төв байгууллага нь энэхүү журмын 6.1.1-6.1.6-д заасан үүргээ Усан замын тээврийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1.14-т "гэрээний үндсэн дээр зарим чиг үүргийг төрийн болон төрийн бус мэргэжлийн байгууллагад шилжүүлэх" гэж заасны дагуу мэргэжлийн байгууллагад шилжүүлж болно.

6.3. Төрийн захиргааны төв байгууллага нь энэ журмын 6.2-т заасан байгууллага гэрчилгээжүүлэлтийг хууль, тогтоомжийн дагуу явуулж байгаа эсэхийг



хянаж, шаардлагатай тохиолдолд мэргэжлийн байгууллагын гаргасан дүгнэлт, шийдвэрийг хүчингүй болгох эрхтэй.

6.4. Гэрчилгээний загварыг усан замын тээврийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн батлах ба гэрчилгээнд объектын код, нэр, төрөл, хүчинтэй хугацаа, техникийн үзүүлэлтүүд, олгосон байгууллага, эрх бүхий албан тушаалтны нэр, тухайн объектын өмчлөгчийн нэр, хаяг, гэрчилгээний дугаар, олгосон он, сар, өдрийг тэмдэглэнэ.

## **Долоо. Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг**

### **7.1 Гэрчилгээ эзэмшигчийн эрх, үүрэг**

7.1.1. гэрчилгээ эзэмшигч нь усан замын тээврийн аюулгүй байдлыг хангах нөхцөл шаардлагыг биелүүлэх, объектын үндсэн эд ангид засвар өөрчлөлт орсон бол энэ тухай хуанлийн 30 хоногийн дотор төрийн захиргааны төв, эсхүл гэрчилгээ олгосон байгууллагад мэдэгдэнэ.

7.1.2. гэрчилгээний хүчинтэй хугацаанд объектын хэвийн ашиглалт, хөвөлтийн аюулгүй байдалд нөлөөлж болох технологийн процесс, бүтэц, үйл ажиллагаанд өөрчлөлт оруулах тохиолдолд гэрчилгээ эзэмшигч нь энэ тухай төрийн захиргааны төв, эсхүл гэрчилгээ олгосон байгууллагад урьдчилан мэдэгдэнэ.

7.1.3. энэ журмын 7.1.1-т заасан өөрчлөлтийг хийсэн бол төрийн захиргааны төв, эсхүл гэрчилгээ олгосон байгууллага нь гэрчилгээнд тухайн өөрчлөлтийг тэмдэглэх эсхүл гэрчилгээг шинэчлэн олгоно. Гэрчилгээг шинэчлэн олгох асуудлыг энэ журмын 6-д заасны дагуу хянан шийдвэрлэнэ.

## **Найм. Гэрчилгээний хугацааг сунгах**

### **8.1. Гэрчилгээний хугацаа:**

8.1.1. объектын гэрчилгээний хугацаа 3 жил байна.

8.1.2. гэрчилгээ нь олгосон өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болох бөгөөд хугацаа дууссанаар уг гэрчилгээ хүчингүйд тооцогдоно.

8.2. Гэрчилгээний хугацааг дуусахаас 30 хоногийн өмнө сунгуулах тухай хүсэлтээ усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүний эрх олгосон мэргэжлийн байгууллагад бичгээр гаргана.

8.3. Хүсэлтэд дараах баримт бичгийг хавсаргана. Үүнд:

8.3.1. объектын гэрчилгээг сунгуулах тухай зохих журмын дагуу гаргасан хүсэлт, өргөдөл;

8.3.2. объектын хугацаа дууссан гэрчилгээний эх хувь;

8.3.3. гэрчилгээжүүлсэн объектын ашиглалтын тайлан /захиалагч байгууллагаас гаргасан тодорхойлолт, үйл ажиллагааны үр дүнг нотлох баримт бичиг, акт, тухайн байгууламжийн дэвсгэр зураг, фото зураг зэрэг болно/;

8.3.4. гэрчилгээг анх авахдаа бүрдүүлж өгсөн мэдээлэлд орсон өөрчлөлтийн тухай мэдээлэл;

8.3.5. татварын байгууллагын тодорхойлолт.

8.4. Гэрчилгээний хугацааг сунгуулах тухай өргөдлийг энэ журмын 8.2-т заасан хугацаанд ирүүлээгүй тохиолдолд хариуцлага тооцсоны үндсэн дээр сунгалт хийх, эсхүл гэрчилгээ шинээр олгох журмыг баримтална.

### **Ес. Гэрчилгээг түдгэлзүүлэх, хүчингүй болгох**

9.1. Гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлэх үндэслэл:

9.1.1. гэрчилгээ олгох, сунгахад тавигдах нөхцөл, шаардлагыг зөрчсөн;

9.1.2. энэ журмын 7.1-д заасныг зөрчсөн;

9.1.3. гэрчилгээ эзэмшигчийн хууль бус үйл ажиллагааны улмаас иргэд, хуулийн этгээдийн эрх ашиг зөрчигдсэн, хохирол учруулсан нь шүүхээр тогтоогдсон.

9.2. Усан замын тээврийн хяналтын улсын байцаагчаас гэрчилгээг хүчингүй болгуулах, үйлчлэлийг түдгэлзүүлэх тухай гаргасан саналын дагуу төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх олгосон байгууллага хянан үзэж гэрчилгээг хүчингүй болгох, түдгэлзүүлэх асуудлыг шийдвэрлэнэ.

9.3. Гэрчилгээжсэн объектын үйл ажиллагааг түдгэлзүүлсэн нөхцөлийг арилгасан тохиолдолд уг гэрчилгээний үйлчлэлийг сэргээж болно.

9.4. Гэрчилгээг хүчингүй болгох үндэслэл:

9.4.1. гэрчилгээ эзэмшигч өөрөө хүсэлт гаргасан;

9.4.2. гэрчилгээжсэн объектод тавигдах нөхцөл, шаардлагыг удаа дараа буюу ноцтой зөрчсөн;

9.4.3. гэрчилгээний үйлчлэлийг түдгэлзүүлсэн хугацаанд зөрчлийг арилгах талаар тавьсан шаардлагыг биелүүлээгүй;

9.4.4. гэрчилгээг авахдаа хуурамч бичиг баримт бүрдүүлсэн нь тогтоогдсон;

9.4.5. гэрчилгээ эзэмшигч хуулийн этгээд татан буугдсан, дампуурсан.

9.5. Гэрчилгээг хүчингүй болгосон тухай мэдэгдлийг гэрчилгээ эзэмшигч, холбогдох объект өмчлөгч буюу эзэмшигч, тээвэрлэгчид албан бичгээр мэдэгдэнэ.

9.6. Хугацаа дууссан буюу хүчингүй болгосон гэрчилгээг төрийн захиргааны төв байгууллага, эсхүл түүнээс эрх олгосон байгууллага хураан авна.

### **Арав. Хяналт**

10.1. Төрийн захиргааны төв байгууллага, түүний эрх олгосон мэргэжлийн байгууллага, Мэргэжлийн хяналтын байгууллага нь гэрчилгээжүүлэлтэд хамрагдсан объектын үйл ажиллагаанд хууль тогтоомжоор олгогдсон бүрэн эрхийн хүрээнд хяналт тавина.

### **Арван нэг. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан**

11.1. Гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн сан нь дараах мэдээллүүдийг агуулна. Үүнд:

- 11.1.1. стандарт, норматив, баримт бичиг;
- 11.1.2. гэрчилгээжүүлсэн объектуудын нэр, эзэмшигч, хаяг, байршил, утас;
- 11.1.3. объектын ангилал, төрөл;
- 11.1.4. гэрчилгээ олгосон огноо;
- 11.1.5. гэрчилгээ олгосон байгууллага;
- 11.1.6. гэрчилгээ сунгасан эсэх.

11.2. Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээжүүлэлтийн дараа хийгдсэн засвар, үйлчилгээ, өөрчлөлтийн талаарх болон бусад мэдээллээр гэрчилгээжүүлэлтийн мэдээллийн санг баяжуулна.

---oOo---

## УСАН ЗАМЫН ТЭЭВРИЙН АЮУЛГҮЙ БАЙДАЛТАЙ ХОЛБООТОЙ ОБЪЕКТЫН ГЭРЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР

### ГЭРЧИЛГЭЭНИЙ НҮҮРЭН ТАЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА

1. Гэрчилгээ нь нууцлал бүхий үнэт цаас байна.
2. Гэрчилгээний хэмжээ нь 21 см-ийн өргөнтэй, 29,7 см-ийн урттай байх ба 157 граммтай цаасыг ашиглана.
3. Гэрчилгээний дээд хүрээнээс 5,5 мм-ийн зайд, төв хэсэгт нь 17x35 мм хэмжээтэй соёмбо байрлуулна. Соёмбо нь MNS 6262:2011 стандартад заасан шаардлагыг хангасан байна.
4. Гэрчилгээний дээд хэсэгт байрлах соёмбын доод талд усан замын тээврийн асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагын нэрийг том үсгээр бичсэн байна.
5. Объектын гэрчилгээнд бичигдэх өгөгдлүүд нь монгол хэл дээр бичигдсэн байна.
6. Гэрчилгээнд бичигдсэн Төрийн захиргааны төв байгууллагын нэрийн доод талд “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ” гэсэн гарчиг байх ба түүний баруун доод талд гэрчилгээний дугаарыг бичнэ.
7. “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээ олгох журам”-д заагдсан нэр төрөл бүр дээр дугаарлалт хийнэ.
8. Гэрчилгээнд сунгалт хийх үед тухайн дугаарын ард сунгалт хийсэн оны арын хоёр орныг бичнэ.
9. Гэрчилгээний дугаарын зүүн доод талд тухайн гэрчилгээний төрөлд оногдох кодыг бичнэ.
10. Гэрчилгээний дунд хэсэгт гэрчилгээ эзэмшигч байгууллага, иргэн, аж ахуйн нэгжийн нэр, албан ёсны хаяг, гэрчилгээ олгож байгаа объектын нэр төрөл, зориулалтыг тодорхойлж бичнэ.
11. Гэрчилгээний доод хэсэгт олгосон он, сар, өдөр, хүчинтэй хугацааг заана.

## ГЭРЧИЛГЭЭНИЙ АР ТАЛ, ТҮҮНИЙ АГУУЛГА

1. Объектын гэрчилгээний ард тухайн объектод хамаарагдах дараах шаардлагатай тодорхойлолт, өгөгдлийг тусгана.

### 1. Усан замын зогсоол

<b>Усан замын зогсоол</b>		
№	Техникийн нөхцөл	Үзүүлэлт
1	Зориулалт /төрөл/	
2	Нийт талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	
3	Даац	
4	Хүчин чадал	
5	Зогсоолын урт	
6	Байгууламжийн байршил	
7	Тоног төхөөрөмж	
8	Ашиглалтад орсон огноо	
9	Бэхэлгээний тоо /уяа, оосор/	
10	Зогсоол дээрх бусад байгууламж /шатахуун, түлшний агуулах, сав/	
11	Гэрэлтүүлэг /тоо, ширхэг/	
-	Бусад	

### 2. Усан замын төв буудал

<b>Усан замын төв буудал</b>		
№	Техникийн нөхцөл	Үзүүлэлт
1	Зориулалт /төрөл/	
2	Нийт талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	
3	Даац	
4	Хүчин чадал	
5	Зогсоолын урт	
6	Байгууламжийн байршил	
7	Тоног төхөөрөмж	
8	Ашиглалтад орсон огноо	
9	Зогсоол дээрх бусад байгууламж /шатахуун, түлшний агуулах, сав/	
10	Гэрэлтүүлэг /тоо, ширхэг/	
11	Бусад	

### 3. Чиглүүлэгч гэрэлт цамхаг

<b>Чиглүүлэгч гэрэлт цамхаг</b>		
№	Техникийн нөхцөл	Үзүүлэлт
1	Зориулалт /төрөл/	
2	Нийт талбайн хэмжээ /м <sup>2</sup> /	
3	Даац	
4	Хүчин чадал	
5	Байгууламжийн байршил	

6	Тоног төхөөрөмж	
7	Ашиглалтад орсон огноо	
8	Гэрэлтүүлэг /тоо, ширхэг/	
9	Бусад	

4. Бусад хөвөгч тоног төхөөрөмж

Бусад хөвөгч тоног төхөөрөмж		
№	Техникийн нөхцөл	Үзүүлэлт
1	Зориулалт /төрөл/	
2	Хэмжээ	
3	Даац	
4	Хүчин чадал	
5	Тоног төхөөрөмж	
6	Ашиглалтад орсон огноо	
7	Бэхэлгээ	
8	Гэрэлтүүлэг /тоо, ширхэг/	
9	Бусад	

Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектын гэрчилгээний код:

№	Гэрчилгээний Код	Объект	Хугацаа
1	О-УЗЗ	Усан замын зогсоол	3 жил
2	О-УЗТБ	Усан замын төв буудал	3 жил
3	О-ЧГЦ	Чиглүүлэгч гэрэлт цамхаг	3 жил
4	О-БХТТ	Бусад хөвөгч тоног төхөөрөмж	3 жил

Жич: О-объект

УЗЗ- Усан замын зогсоол

УЗТБ- Усан замын төв буудал

ЧГЦ- Чиглүүлэгч гэрэлт цамхаг

БХТТ- Бусад хөвөгч тоног төхөөрөмж

---oOo---

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ  
ТӨМӨР ЗАМ, ДАЛАЙН БОДЛОГЫН  
ХЭРЭГЖИЛТИЙГ ЗОХИЦУУЛАХ ГАЗРЫН  
ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН  
ГҮЙЦЭТГЭГЧ А.БАТБОЛД  
ТАНАА


2018.11.28 014

Санал хүргүүлэх тухай

“Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ нь “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ын төсөлтэй танилцаж тус журмын төслийг “Монголын завьчдын нэгдсэн холбоо” НҮТББ-ын Фэйсбүүк цахим хуудасны группдээ нэг сарын хугацаанд байршуулан холбооны бүх гишүүддээ танилцуулж, онлайн аар хэлэлцүүлэг зохион байгууллаа.

Манай холбооны цахим хуудасны группд аж ахуй нэгж, иргэдийг тус тус оролцуулан 60 гишүүн байснаас 42 гишүүн саналд амрагдаж “Усан замын тээврийн аюулгүй байдалтай холбоотой объектод гэрчилгээ олгох журам”-ын төсөлд ямар нэгэн нэмэлт өөрчлөлт, тусгайлан өгөх саналгүйгээр уг журмын төслийг дэмжиж буйг илэрхийлэн хүргүүлж байна.

Хувийг : “ Монгол улсын далайн захиргаа” УТҮГ-т

“МОНГОЛЫН ЗАВЬЧДЫН НЭГДСЭН ХОЛБОО”  
НҮТББ-ЫН ТЭРГҮҮН  Б.БИЛГҮҮН

Захиргааны хэм ш. 2019 оны 03 сарын 22 өдрийн 232 дугаар бүртгээ.



МОНГОЛ УЛСЫН  
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН  
САЙДЫН ТУШААЛ

2019 оны 03 сарын 04 өдөр

Дугаар 60

Улаанбаатар хот

Агаарын замуудыг тогтоох тухай

Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Агаарын зайг нисэхэд ашиглах тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4 дэх хэсэг, Иргэний нисэхийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Монгол Улсын агаарын зайд иргэний нисэхийн зориулалтаар ашиглах үзүүлэлтэд тулгуурласан навигаци бүхий агаарын замуудыг Нэгдүгээр, дээд агаарын замуудыг Хоёрдугаар, доод агаарын замуудыг Гуравдугаар хавсралтаар тус тус тогтоосугай.

2. Тогтоосон агаарын замуудыг зохих журмын дагуу зарлан мэдээлж, аюулгүй ажиллагааг ханган ажиллахыг Иргэний нисэхийн ерөнхий газар /Л.Бямбасүрэн/-д, тушаалын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Агаарын тээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах хэлтэс /Д.Мягмарсүрэн/-д тус тус даалгасугай.

3. Энэхүү тушаал гарсантай холбогдуулан Зам, тээврийн сайдын (хуучнаар) "Агаарын замуудыг шинэчлэн тогтоох тухай" 2013 оны 08 дугаар сарын 28-ны өдрийн 187, "Агаарын замд өөрчлөлт оруулах тухай" 2014 оны 03 дугаар сарын 26-ны өдрийн 71, "Агаарын замд өөрчлөлт оруулах тухай" 2015 оны 05 дугаар сарын 27-ны өдрийн 154, "Агаарын замуудыг шинээр болон шинэчлэн тогтоох тухай" 2015 оны 09 дүгээр сарын 10-ны өдрийн 232, "Агаарын замд өөрчлөлт оруулах тухай" 2016 оны 03 дугаар сарын 31-ний өдрийн 79, "Үндсэн цэгүүдийн нэр болон солбицол өөрчлөх тухай" 2018 оны 09 дүгээр сарын 12-ны өдрийн 203 дугаар тушаалуудыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

САЙД  Б.ЭНХ-АМГАЛАН

Бэлтгэгч/хариуцагч 86  
19 03 05



Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 2 дугаар сарын 28 ны өдрийн дугаар тушаалын нэгдүгээд авсрагт

МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙН ҮЗҮҮЛЭЛТЭД ТУЛГУУРЛАСАН НАВИГАЦИ БҮХИЙ АГААРЫН ЗАМУУД

Агаарын замын дугаар	№	Маршрут	Солбицлууд		Илтгэх цэг	Соронзон хазайлт	Бодит чиглэл	Соронзон чиглэл	Өргөн (км)	Зай (км-ийн 1/100)	Доод өндрийн хязгаар (м)	Дээд өндрийн хязгаар (м)	Чиглэл
			48 30 51,0	115 47 12,0									
Y165	1	SARUL-PICAS	46 42 06,1	114 07 42,6	Цэг	7.4 W	31.1	38.5	22	236.95	7350	14600	↓
			50 29 24,0	091 25 48,0	Цэг	3.2 E	132.7	129.5	22	228.73	7350	14600	
	3	ALTAN-URGAM	49 04 17,0	093 43 47,0	Цэг	1.7 E	314.4	312.7	22	78.75	7350	14600	↓
			48 34 24,0	094 29 32,0	Цэг	1.2 E	314.9	313.7	22	282.57	7350	14600	
Y962	4	URGAM-PARAL	45 44 43,9	097 06 24,2	Цэг	0.1 W	316.9	317.0	22	416.72	7350	14600	↓
			45 44 43,9	097 06 24,2	Цэг	0.1 W	136.8	136.9	22	276.55	7350	14600	
	5	PARAL-GUMEN	43 57 04,5	100 39 15,3	Цэг	1.6 W	319.4	321.0	22	115.28	7350	14600	↓
			43 57 04,5	100 39 15,3	Цэг	1.6 W	139.6	141.2	22	83.85	7350	14600	
Y478	7	NOPUS-BUGAT	42 02 00,0	102 49 00,0	Цэг	2.1 W	321.1	323.2	22	84.77	7350	14600	↓
			49 38 00,0	089 26 00,0	Цэг	3.7 E	124.1	120.4	22	301.94	7350	14600	
	8	BUGAT-BUREG	49 02 37,1	090 44 17,0	Цэг	3.0 E	305.1	302.1	22	217.39	7350	14600	↓
			48 36 22,2	091 40 05,8	Цэг	2.4 E	305.8	303.4	22		7350	14600	
9	BUREG-HARUS	48 36 22,2	091 40 05,8	Цэг	2.4 E	125.7	123.3	22		7350	14600	↓	
		48 09 25,1	092 35 34,8	Цэг	1.9 E	306.4	304.5	22		7350	14600		↓
10	HARUS-IMBAT	48 09 25,1	092 35 34,8	Цэг	1.9 E	126.4	124.5	22		7350	14600	↓	
		46 30 00,0	095 45 31,3	Цэг	0.3 E	308.7	308.4	22		7350	14600		↓
		46 30 00,0	095 45 31,3	Цэг	0.3 E	128.7	128.4	22		7350	14600		
11	IMBAT-TANIUK	45 15 16,4	097 55 05,3	Цэг	0.6 W	310.3	310.9	22		7350	14600	↓	
		45 15 16,4	097 55 05,3	Цэг	0.6 W			22		7350	14600		↓

ХҮҮГИЙН ГАЗАР  
2019.03.05

Y683	12	TANUK-ERKEM	45 15 16,4	097 55 05,3	Ljar	0,6	W	130,3	130,9	22	256,07	7350	14600	↓	
			43 44 15,4	100 20 32,1	Ljar	1,4	W	312,0	313,4						
		13	ERKEM-MORIT	43 44 15,4	100 20 32,1	Ljar	1,4	W	132,2	133,6	22	276,93	7350	14600	↓
				42 02 00,0	102 49 00,0	Ljar	2,1	W	313,9	316,0					
		14	NIGOR-MINOG	50 29 24,0	091 25 48,0	Ljar	3,2	E	111,4	108,2	22	228,90	7350	14600	↓
				49 41 54,7	094 22 59,8	Ljar	1,5	E	293,7	292,2					
		15	MINOG-SAGIM	49 41 54,7	094 22 59,8	Ljar	1,5	E	113,5	112,0	22	184,17	7350	14600	↓
				49 00 50,9	096 41 30,9	Ljar	0,3	E	295,2	294,9					
		16	SAGIM-PIKOM	49 00 50,9	096 41 30,9	Ljar	0,3	E	115,5	115,2	22	24,05	7350	14600	↓
				48 55 13,9	096 59 17,0	Ljar	0,2	E	295,7	295,5					
	17	PIKOM-TEMEN	48 55 13,9	096 59 17,0	Ljar	0,2	E	115,3	115,1	22	214,51	7350	14600	↓	
			48 03 53,8	099 35 22,4	Ljar	1,0	W	297,2	298,2						
	18	TEMEN-FOSAT	48 03 53,8	099 35 22,4	Ljar	1,0	W	117,4	118,4	22	315,70	7350	14600	↓	
			46 41 50,8	103 15 15,8	Ljar	2,7	W	300,1	302,8						
	19	FOSAT-MIDAS	46 41 50,8	103 15 15,8	Ljar	2,7	W	119,9	122,6	22	97,36	7350	14600	↓	
			46 15 19,9	104 20 56,6	Ljar	3,1	W	300,6	303,7						
	20	MIDAS-DIROT	46 15 19,9	104 20 56,6	Ljar	3,1	W	120,8	123,9	22	382,18	8250	14600	↓	
			44 25 00,8	108 28 13,8	Ljar	4,6	W	303,7	308,3						
	21	DIROT-NIXAL	44 25 00,8	108 28 13,8	Ljar	4,6	W	123,7	128,3	22	235,81	8250	14600	↓	
			43 12 42,0	110 53 00,0	Ljar	5,2	W	305,4	310,6						
	22	DARNO-SETEM	50 21 24,0	098 17 42,0	Ljar	0,0		124,8	124,8	22	143,03	8250	14600	↓	
			49 36 34,8	099 55 06,4	Ljar	0,9	W	306,1	307,0						
	23	SETEM-DALAM	49 36 34,8	099 55 06,4	Ljar	0,9	W	126,1	127,0	22	159,41	8250	14600	↓	
			48 45 03,2	101 40 09,2	Ljar	1,9	W	307,4	309,3						
	24	DALAM-LAGON	48 45 03,2	101 40 09,2	Ljar	1,9	W	127,4	129,3	22	74,06	8250	14600	↓	
			48 20 36,1	102 27 45,9	Ljar	2,3	W	308,0	310,3						
	25	LAGON-SERAT	48 20 36,1	102 27 45,9	Ljar	2,3	W	127,9	130,2	22	86,28	8250	14600	↓	
			47 51 43,5	103 22 17,7	Ljar	2,1	W	308,6	311,3						
	26	SERAT-PASON	47 51 43,5	103 22 17,7	Ljar	2,7	W	128,6	131,3	22	178,40	8250	14600	↓	
			46 50 43,2	105 11 54,6	Ljar	3,3	W	309,9	313,4						
	27	PASON-BUDEN	46 50 43,2	105 11 54,6	Ljar	3,5	W	129,9	133,4	22	366,76	8250	14600	↓	
			44 40 07,9	108 44 34,6	Ljar	4,7	W	312,5	317,2						

86

19 03 05

Dem

28	BUDEN-NIXAL	44 40 07,9	108 44 34,6	Ljar	4,7	W	132,5	137,2	22	236,08	8250	14600	↓
		43 12 42,0	110 53 00,0	Ljar	5,2	W	314,0	319,2					
29	ULAAANBAATAR (UDA) -LIMAR	47 52 04,0	106 44 01,0	VOR/DME	4,2	W	146,4	150,6	22	257,55	6150	14600	↓
		45 55 19,7	108 34 08,4	Ljar	4,9	W	327,7	332,6					
30	LIMAR-BIKOT	45 55 19,7	108 34 08,4	Ljar	4,9	W	147,7	152,6	22	148,85	6150	14600	↓
		44 47 04,8	109 34 19,1	Ljar	5,1	W	328,4	333,5					
31	BIKOT-NIXAL	44 47 04,8	109 34 19,1	Ljar	5,1	W	148,5	153,6	22	203,98	6150	14600	↓
		43 12 42,0	110 53 00,0	Ljar	5,2	W	329,4	334,6					
32	AMUTA-BUGAN	50 22 30,0	104 52 30,0	Ljar	3,1	W	141,6	144,7	22	206,70	7350	14600	↓
		48 54 13,4	106 37 25,8	Ljar	4,1	W	322,9	327,0					
33	BUGAN-SANOT	48 54 13,4	106 37 25,8	Ljar	4,1	W	142,9	147,0	22	134,88	7350	14600	↓
		47 55 51,4	107 42 44,6	Ljar	4,6	W	323,7	328,3					
34	SANOT-VIZOT	47 55 51,4	107 42 44,6	Ljar	4,6	W	143,7	148,3	22	126,10	7350	14600	↓
		47 00 43,1	108 41 34,8	Ljar	5,0	W	324,4	329,4					
35	VIZOT-SUMOR	47 00 43,1	108 41 34,8	Ljar	5,0	W	144,4	149,4	22	251,08	7350	14600	↓
		45 09 31,6	110 32 58,5	Ljar	5,6	W	325,7	331,3					
36	SUMOR- INTIK	45 09 31,6	110 32 58,5	Ljar	5,6	W	145,7	151,3	22	196,02	7350	14600	↓
		43 41 30,0	111 55 00,0	Ljar	5,8	W	326,7	332,5					
37	POLHO-ZOBUL	44 47 00,0	113 15 00,0	Ljar	6,6	W	17,4	24,0	22	200,46	8650	14600	↓
		46 30 04,0	114 02 02,0	Ljar	7,3	W	198,0	205,3					
38	ZOBUL-PICAS	46 30 04,0	114 02 02,0	Ljar	7,3	W	17,9	25,2	22	23,44	8650	14600	↓
		46 42 06,1	114 07 42,6	Ljar	7,4	W	198,0	205,4					
39	PICAS-BURIM	46 42 06,1	114 07 42,6	Ljar	7,4	W	18,0	25,4	22	174,80	8650	14600	↓
		48 11 38,0	114 51 32,0	Ljar	7,9	W	198,5	206,5					
40	BURIM-SULOK	48 11 38,0	114 51 32,0	Ljar	7,9	W	18,6	26,5	22	200,60	8650	14600	↓
		49 54 00,0	115 45 00,0	Ljar	8,5	W	199,2	207,7					
41	SERNA-BUGAN	50 18 30,0	106 28 06,0	Ljar	3,9	W	175,8	179,7	22	156,62	8650	14600	↓
		48 54 13,4	106 37 25,8	Ljar	4,1	W	355,9	360,0					
42	BUGAN- ULAAANBAATAR (UDA)	48 54 13,4	106 37 25,8	Ljar	4,1	W	175,9	180,0	22	115,48	8650	14600	↓
		47 52 04,0	106 44 01,0	VOR/DME	4,2	W	356,0	360,2					

86

19 03 05

Y345	43	UULAANBAATAR (UDA)-VIZOT	47 52 04,0	106 44 01,0	VOR/DME	4.2	W	122.0	126.2	22	175.76	8650	14600	↑
			47 00 43,1	108 41 34,8	Цэр	5.0	W	303.4	308.4					
			47 00 43,1	108 41 34,8	Цэр	5.0	W	123.4	128.4	22	37.69	8650	14600	↑
			46 49 27,0	109 06 18,0	Цэр	5.2	W	303.7	308.9					
			46 49 27,0	109 06 18,0	Цэр	5.2	W	123.5	128.7	22	193.98	8650	14600	↑
			45 50 22,0	111 11 06,0	Цэр	5.9	W	305.0	310.9					
			45 50 22,0	111 11 06,0	Цэр	5.9	W	125.1	131.0	22	199.99	8650	14600	↑
			44 47 00,0	113 15 00,0	Цэр	6.6	W	306.6	313.2					
			50 18 30,0	106 28 06,0	Цэр	3.9	W	137.7	141.6	22	200.09	8650	14600	↑
			48 57 40,0	108 18 15,0	Цэр	4.9	W	319.1	324.0					
Y520	48	PRING-GOBEZ	48 57 40,0	108 18 15,0	Цэр	4.9	W	139.1	144.0	22	136.85	8650	14600	↑
			48 01 27,0	109 30 17,0	Цэр	5.4	W	320.0	325.4					
			48 01 27,0	109 30 17,0	Цэр	5.4	W	140.0	145.4	22	18.24	8650	14600	↑
			47 53 54,0	109 39 41,0	Цэр	5.5	W	320.1	325.6					
			47 53 54,0	109 39 41,0	Цэр	5.5	W	140.0	145.5	22	242.87	8650	14600	↑
			46 12 17,0	111 40 51,0	Цэр	6.2	W	321.5	327.7					
			46 12 17,0	111 40 51,0	Цэр	6.2	W	141.6	147.8	22	199.99	8650	14600	↑
			44 47 00,0	113 15 00,0	Цэр	6.6	W	322.7	329.3					

86

19 03 05  
Dm

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны 03 дугаар сарын 04 ны өдрийн 60 дугаар тушаалын Хоёрдугаар хавсралт

### МОНГОЛ УЛСЫН АГААРЫН ЗАЙН ДЭЭД АГААРЫН ЗАМУУД

Агаарын замын дугаар	№	Маршрут	Солбицлууд		Соронзон хазайлт	Бодит чиглэл	Соронзон чиглэл	Өргөн (км)	Зай (км-ийн 1/100)	Доод өндрийн хязгаар (м)	Дээд өндрийн хязгаар (м)	Чиглэл
A308	1	GINOM-HATGA	51 00 00.0	097 52 00.0	0.3	E	110.3	110.0	171.81	6150	14600	↑
			50 26 25.0	100 08 04.0	0.9	W	292.1	293.0				
	2	HATGA-BULAG	50 26 25.0	100 08 04.0	0.9	W	124.8	125.7	298.7	6150	14600	↑
			48 51 21.2	103 28 30.2	2.7	W	307.4	310.1				
	3	BULAG-NOMUN	48 51 21.2	103 28 30.2	2.7	W	127.7	130.4	58.58	7350	14600	↑
